МЭДЭЭ · 2020 оны 6-р сарын 30

ШИНЭ, ЗАЛУУ МӨРДӨГЧДӨД ЗОРИУЛСАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Хан-Уул дүүргийн прокурорын газраас тус дүүрэг дэх Цагдаагийн газрын шинэ, залуу мөрдөгчдөд зориулсан сургалтыг зохион байгуулсан байна.

Тус дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор О.Алтангэрэл "Залилах гэмт хэргийг иргэний эрх зүйн аливаа харилцаанаас ялгаж шалгахад анхаарах асуудал", "Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрч, хохирогч, яллагдагчаас мэдүүлэг авахад анхаарах асуудал" гэсэн сэдвээр мөрдөгчдөд мэдээлэл өгсөн бол орлогч, ахлах прокурорууд зарим хэргийг хэрхэн шалгах талаар зөвлөмж өгчээ.